



2025оны 2-р улиралд

Чусон их сургууль
Бакалаврын түвшинд
гадаад оюутан
элсүүлэх удирдамж



조선대학교
CHOSUN UNIVERSITY

Чусон их сургууль




2025оны 1-р улиралд

Бакалаврын түвшинд гадаад оюутан

элсүүлэх журам

Contents

1. Сонгон шалгаруулалтын хуваарь	04
2. Сонгон шалгаруулалтын аргачлал	05
3. Өргөдлийн нөхцөл	06
4. Бүрдүүлэх бичиг баримт	07
5. Баримт бичгийг бүрдүүлэхэд анхаарах зүйлс	08
6. Тэнцэгчийн бүртгэл визний мэдээлэл	09
7. Шалгаруулах мэдээлэл	10




8.Сургалтын төлбөр	12
9.Тэтгэлэг	12
10.Бусад мэдээлэл	13
11.Дотуур байр	14
12.Анхаарах зүйлс	15
13.Маягт	17

Ангилал	Хуваарь	
	1-р шат	2-р шат
Онлайн өргөдөл гаргах, хэвлэх	2025. 4. 7.(Даваа) 10:00 ~ 5. 9.(Баасан) 17:00	2025. 6. 30.(Даваа) 10:00 ~ 7. 11.(Баасан) 17:00
	■ 2-р шатны элсэгчийн бүртгэл нь зөвхөн БНСУ-д оршин суудаг хүмүүс болон Глобал бакалаврийн сургуульд өргөдөл гаргагчдад нээлттэй. ■ элсэх өргөдлийг онлайнаар бөглөх. - Өргөдөл гаргах:Чусон их сургуулийн шалгагдагч оюутны вэб үйлчилгээ [https://n.chosun.ac.kr/fr/app] - Өргөдлийн лавлагаа,хэвлэх: Чусон их сургуулийн шалгагдагч оюутны вэб үйлчилгээ [https://n.chosun.ac.kr/fr/]	
Элсэх өргөдөл (хэвлэсэн хуулбар) ба Эх хувь баримт бичгийг ирүүлэх	~2025. 5. 16.(Баасан)	~2025. 7. 11.(Баасан)
	■ Онлайнаар өргөдөл гаргасны дараа анкет болон бусад баримт бичгийг шуудангаар эсвэл биечлэн авч ирж өгөх хэрэгтэй. - Хаяг : [61452] гванжу хот, Чусон Их Сургууль 5-р замын 9, Чусон Их Сургуулийн Олон улсын хамтын ажиллагааны баг'Бакавларын хариуцагч' - Утас : 062-230-6495 - Address: [61452] International Affairs Team 'Foreign Undergraduate Officer', Chosun University, 9, Chosundae 5-gil, Dong-gu, Gwangju, Republic of Korea - Phone number: +82-62-230-6495 ■ Баримт бичиг хүлээн авах эцсийн хугацаа хүртэл бүх баримт бичгийг ирүүлээгүй тохиолдолд ярилцлагад орох боломжгүй бөгөөд таныг тэнцээгүйд тооцож хасах болно. ※ Онлайн өргөдлийн хугацаанд эхлээд хуулбар файлыг байршуулж,дараа нь эх хувийг илгээнэ.	
CSU-TOPIK	2025. 4. 29.(мягмар) төлөвлөсөн	
	■ CSU-TOPIK шалгалтын дэлгэрэнгүй хуваарь их сургуулийн вэб сайт дээр зарлагдана. - Чусон их сургуулийн Олон улсын хамтын ажиллагааны багийн вэб сайт [https://www3.chosun.ac.kr/global/index.do] - [Community] - [(Int'l)Notice]	
Ярилцлага	2025. 5. 26.(Даваа) ~ 5. 30.(Баасан)	2025. 7. 12.(Бямба) ~ 7. 17.(Пүрэв)
	■ Ярилцлагын дэлгэрэнгүй хуваарийг өргөдөл гаргагч бүрт имэйлээр мэдэгдэнэ. - Солонгост оршин суугч: нүүр тулсан ярилцлага. / Гадаадад оршин суугч: утсаар эсвэл видео ярилцлага. - Урлаг ,спортын мэргэжлээр элсэхийг хүсэгчид тэнхимээс хамааран ярилцлагын үеэр бодит чадварын шалгалт өгч болно.	
Тэнцэгчдийн нэрс зарлах	2025. 6. 20.(Баасан)	2025. 7. 25.(Баасан)
	■ Сургуулийн вэб сайт дээр шалгаруулалтад нийт тэнцэгчдийн нэрсийг зарлах болон хүн бүрт имэйлээр мэдэгдэнэ. -Чусон их сургуулийн Олон улсын хамтын ажиллагааны багийн вэб сайт [https://www3.chosun.ac.kr/global/index.do] -[Admission] - [Admission Result]	
Төлбөр төлөлт	2025. 7. 7.(Даваа) 10:00 ~ 7. 11.(Баасан) 16:00	2025. 7. 28.(Даваа) 10:00 ~ 8. 1.(Баасан) 16:00
	■ Непал улсаас бусад улсын элсэгчид: 2025. 6. 23.(Даваа) 10:00~6. 27.(Баасан) 16:00 ■ Сургалтын төлбөрийн нэхэмжлэл: Чусон их сургуулийн шалгагдагч оюутны вэб үйлчилгээ [https://n.chosun.ac.kr/fr/] нэвтэрч хүн тус бүрээр хэвлэх. ■ Төлбөр төлөх арга: Амжилттай элсэгчид сургалтын төлбөрөө виртуал дансанд төлнө. ※Төгсөхөөр хүлээгдэж буй төгсөгчид төгсөлтийн гэрчилгээ болон суурь эрдмийн гэрчилгээ ирүүлэх хүртэл стандарт элсэлтийн гэрчилгээ хүлээн авах боломжгүй.	
Стандарт элсэлтийн гэрчилгээ олгох	Сургалтын төлбөр төлж, шаардлагатай бичиг баримтыг хянан баталгаажуулсны дараа стандарт элсэлтийн гэрчилгээ илгээгдэнэ.	
Хичээлийн шинэ жил эхлэх	2025. 9. 1.(Даваа)	

※ дээрх цагийн хуваарь нь солонгос цагийн хуваарийг дагаж мөрддөг ба элсэлтийн хуваариас хамааран нарийвчилсан хуваарь өөрчлөгдөх боломжтой.

1. Сонгон шалгаруулалтын журам



2. Сонгон шалгаруулалтын аргачлал

Аргачлал	Үнэлгээний агуулга	Онооны стандарт
Бичиг баримт	Өргөдөл, Солонгос хэлний мэдлэгийн оноо,бүтээл(шаардлагатай тэнхим) гэх мэтийг иж бүрэн хянана	Шаардлага хангасан/хангаагүй
Ярилцлага	Хэлний ур чадвар,Суралцах хүсэл эрмэлзэл,Гадаадад суралцах орчин ※ Солонгос хэлээр явагдах.	100

- Тэнцэх шалгуур: Нийт 70 ба түүнээс дээш оноо авсан хүмүүсийг амжилттай өргөдөл гаргагчаар шалгаруулна
- Үнэлгээний дүнгээр таны эрдмийн чадвар хангалтгүй тохиолдолд сонгон шалгаруулалтад тэнцэхгүй байж болно.



Ангилал

Өргөдөлийн нөхцөл

Иргэншил

- Эцэг,эх сурагчид нь гадаадын иргэншилтэй гадаад хүн байх
- ※Солонгос иргэншилтэй болон давхар иргэншилтэй хүмүүс өргөдөл гаргах эрхгүй

Шинэ болон Шилжих оюутнууд нийтлэг

- Эх орондоо болон гадаадад бага,дунд,ахлах сургуультай дүйцэхүйц сургалтын хөтөлбөрийг төгссөн (эсвэл хүлээгдэж буй)төгсөгчид

Боловсролын түвшин

Шилжих 2-р курс

- Эх орондоо болон гадаадад 4жилийн их сургуульд дор хаяж нэг жил суралцсан (эсвэл дуусгахаар төлөвлөж буй) хүмүүс
- Мэргэжлийн коллеж төгссөн (хүлээгдэж буй)

Шилжих 3-р курс

- Эх орондоо болон гадаадад 4жилийн их сургуульд дор хаяж хоёр жил суралцсан (эсвэл дуусгахаар төлөвлөж буй) хүмүүс
- Мэргэжлийн коллеж төгссөн (хүлээгдэж буй)

Глобал бакалаврын тэнхим

- Хэлний шаардлагаас чөлөөлөх

Хэлний чадвар

Энгийн тэнхимүүд

- Доорх нөхцлүүдээс нэгээс дээш нөхцлийг хангасан байх
 - 1) солонгос хэлний түвшин тогтоох шалгалт(TOPIK) 3-р түвшин, Урлаг,биеийн тамирын сургуулийн хувьд 2-р түвшин ба түүнээс дээш байх
 - 2) Чусон их сургуулийн түвшин тогтоох шалгалтад (CSU-TOPIK) 3ба түүнээс дээш түвшний оноо авсан хүмүүс
 - 3) Дотоодын их,дээд сургуулийн харьяа Солонгос хэлний бэлтгэл дунд ба 3 түүнээс дээш түвшин төгссөн хүмүүс
 - 4) Сэжон институтын дунд болон түүнээс дээш түвшин төгссөн хүмүүс

※Зөвхөн өргөдөл гаргах эцсийн хугацаанд хүчинтэй хэлний оноог хүлээн зөвшөөрнө.

※Дээрх материалд тусгагдаагүй асуудлыг Чусон их сургуулийн Олон улсын хамтын ажиллагааны баг тайлбарлана.



4

Бүрдүүлэх бичиг баримт

ангилал	дд	Бүрдүүлэх бичиг баримт	Эх хувь/хуулбар	Тэмдэглэл
Шинэ элсэгч	1	Элсэх өргөдөл	Эх хувь	- Онлайн хүсэлтийг бөглөсний дараа,хэвлэж гаргаад гарын үсэг зурна.
	2	Өөрийн танилцуулга	Эх хувь	
	3	Суралцах төлөвлөгөө	Эх хувь	
	4	Хувийн мэдээлэл ашиглах зөвшөөрлийн маягт	Эх хувь	
	5	Гадаад паспорт	хуулбар	
	6	Өргөдөл гаргагч болон эцэг эхийн иргэний үнэмлэх	(орчуулга нотариат) Эх хувь	- Өөрийн улсаас олгосон иргэний үнэмлэх болон иргэний үнэмлэхний хуулбар
	7	Гэр бүлийн хамаарлыг нотлох бичиг баримт	(орчуулга нотариат) Эх хувь	- Хятад :Ураг төрлийн гэрчилгээ(эцэг эх болон өргөдөл гаргагч тусдаа байгаа тохиолдолд) эсвэл өрхийн бүртгэлээ ирүүлэх - Хятадаас бусад улсын иргэн: Гэр бүлийн хамаарлыг нотлох баримт бичиг эсвэл төрсний гэрчилгээ
	8	Ахлах сургууль төгссөн(хүлээгдэж байгаа) гэрчилгээ	(орчуулга нотариат) Эх хувь	-Хятад : эрдмийн итгэмжлэлийн төвөөс (CHSI) гаргасан нотлох баримт эсвэл апостиль - Хятадаас бусад: апостиль болон консулын газраас баталгаажуулсан боловсролыг нотлох баримт -Солонгос : төгсөлтийн гэрчилгээ эх хувиар ※төгссөн(хүлээгдэж буй)огнооны мэдээллийг(он,сар) оруулах шаардлагатай
	9	Ахлах сургуулийн дүнгийн тодорхойлолт	(орчуулга нотариат) Эх хувь	- Апостиль мөн төгсөлтийн гэрчилгээ ※ солонгос/англи хэлээр олгосон бичиг баримтын хуулбар боломжтой
	10	Хэлний ур чадварыг нотлох баримт бичиг	Эх хувь	- Хэлний оноотой элсэгч ※Зөвхөн өргөдөл гаргах эцсийн хугацаанд хүчинтэй хэлний оноог хүлээн зөвшөөрнө.
	11	Солонгос хэлний бэлтгэлд суралцаж байгаа/төгссөн гэрчилгээ,дүнгийн тодорхойлолт	Эх хувь	-Хэлний оноотой элсэгч
	12	Дансны үлдэгдлийн баталгаа	Эх хувь	- 16сая вон(Чусон их сургуулийн Солонгос хэлний бэлтгэл,солилцооны оюутан 8сая вон) - Солонгост оршин суугч: өөрийн нэр дээрх Солонгос дансийг л хүлээн зөвшөөрнө ※ тэнцэгчдийг зарласны дараа - Гадаадад оршин суугч: өөрийн болон эцэг эхийн данс ※ өргөдөл гаргахдаа ирүүлнэ ※Баримт бичиг бүрдүүлсэн өдрөөс 30 хоногийн дотор байх
	13	Бусад баримт бичиг	Эх хувь	- Холбогдох хүмүүст хязгаарлагдана
	14	Гадаад иргэний оршин суух үнэмлэх	Хуулбар	- Солонгост оршин суугчдад хамааралтай(урд,ард талыг хуулбарлаж ирүүлнэ)
Шилжин элсэгч	Шинэ элсэлтийн шаардлагатай баримт бичгүүд бүхэлдээ орох (зөвхөн 9 буюу Ахлах сургуулийн дүнгийн тодорхойлолт орохгүй)			
	15	Их сургуулийн төгсөлтийн гэрчилгээ	(орчуулга нотариат) Эх хувь	-Хятад : эрдмийн итгэмжлэлийн төвөөс (CHSI) гаргасан нотлох баримт эсвэл апостиль - Хятадаас бусад: апостиль болон консулын газраас баталгаажуулсан боловсролыг нотлох баримт Солонгос : төгсөлтийн гэрчилгээ эх хувиар ※төгссөн(хүлээгдэж буй)огнооны мэдээллийг(он,сар) оруулах шаардлагатай ※ (сонголтоор1) ахлах сургуулийн төгсөлтийн гэрчилгээ+их сургуулийн төгсөлтийн гэрчилгээ/ их сургуулийн төгсөлтийн гэрчилгээ
	16	Их сургуулийн дүнгийн тодорхойлолт	(орчуулга нотариат) Эх хувь	- Апостиль мөн нотариатаар баталгаажуулсан орчуулга ※ солонгос/англи хэлээр олгосон бичиг баримтын хуулбар боломжтой ※хичээл тус бүрийн кредит болон хувийн үнэлгээ шаардлагатай
	17	Боловсролын түвний лавлагаа авах хүсэлт	Эх хувь	- [хавсралт 3] боловсролын түвшнийг баталгаажуулах хүсэлтийн маягтыг ашиглах

※ Хэрэв бичиг баримт нь солонгос эсвэл англи хэл дээр бичигдээгүй бол орчуулгын хувилбарыг заавал бүрдүүлэх ёстой.
 ※ Бүх бичиг баримт нь бүрдүүлсэн өдрөөс хойш 3 сарын дотор гарган нотариатаар баталгаажуулсан байх ёстой.
 ※ Манай сургуулиас шалгалт хийхэд нэмэлт баримт бичиг шаардвал тухайн баримтыг бүрдүүлэх ёстой.



1. Иргэний харьяалал: Эцэг эх болон өргөдөл гаргагч нь бүгд гадаадын иргэн байх

- Эцэг эхийн аль нэг нь эсвэл өргөдөл гаргагч нь Солонгос улсын давхар иргэншилтэй бол өргөдөл гөргөх боломжгүй.
- Өргөдөл гаргагч нь ахлах сургуульд сурч эхлэхээс өмнө эцэг, эх, сурагчын аль аль нь гадаад иргэншилтэй байх ёстой. (гадаадын иргэншил авсан огноогоор нягтлах)
- Эцэг эх нь салсан/дахин гэрлэсэн, нас барсан гэх мэтийн улмаас бичиг баримт бүрдүүлэхэд хүндрэлтэй байгаа тохиолдолд шалтгааныг нотлох баримт бичгийг бүрдүүлнэ. (төрийн байгууллагаас олгосон бичиг баримт)
 - ※ жишээ: гэр бүр салалтын гэрчилгээ (хятад иргэдийн гэр бүл салсан гэрчилгээ), ганц бие эцэг эхийн гэрчилгээ, нас барсны гэрчилгээ гэх мэт

2. Хэлний ур чадварын оноо

- Зөвхөн баримт бичиг хүлээн авах хугацаанд хүчинтэй оноог хүлээн зөвшөөрнө
- Хэрэв хүчинтэй хугацаа байхгүй бол шалгалтын өдрөөс хойш 2 жил хүртэлх хугацаанд хүчинтэй гэж хүлээн зөвшөөрнө.

3. Боловсролын байдлыг нотлох аргачлал

ангилал	Бүрдүүлэх баримт бичиг
Апостиль гэрээнд нэгдсэн орны төгсөгч	- Төгсөлтийн болон дүнгийн апостиль гэрчилгээ ※ апостиль баталгаажуулалтын гэрээнд нэгдсэн орон эсэхийг шалгах шаардлагатай
Апостиль гэрээнд нэгдээгүй орны төгсөгч	- Төгсөх болон дүнгийн тодорхойлолтын тухай Консулын газраас баталгаажуулсан баримт хэрэгтэй. ※ Гаргагч байгууллага: Холбогдох улс дахь Солонгосын консулын газар эсвэл Солонгос дахь танай улсын элчин сайдын яам - Оршин суугаа улсад Солонгосын консулын газар байхгүй бол: Тухайн улсын хариуцсан ойролцоох хөрш улсын Солонгосын консулын газар гэрчилгээ олгох боломжтой - Хэрэв та өөрийн оршин суугаа улсаас өөр улсад эрдмийн зэрэг хамгаалсан бол: өөрийн оршин суугаа улсдаа байрлах боловсрол эзэмшсэн улсын консулын газраас гэрчилгээ авах боломжтой
	<u>Ахлах сургууль, их дээд сургууль</u> БНХАУ-ын Боловсролын яамны зэрэг баталгаажуулалтын төв (CHSI)-ийн боловсролын гэрчилгээний тайлан <u>Дунд боловсрол</u>
Хятад	① Ердийн дунд мэргэжлийн сургууль (普通中专), Мэргэжлийн ахлах сургууль (职业高中), Насанд хүрэгчдийн дунд мэргэжлийн сургууль (成人中专) [Онлайн] Орон нутгийн боловсролын байгууллагаас олгосон төгсөлтийн гэрчилгээ (Апостиль) ※ Зөвхөн онлайнаар үнэн зөвийг нь шалгах боломжтой тохиолдолд хүчинтэй [Оффлайн] Орон нутгийн боловсролын байгууллагаас олгосон төгсөлтийн гэрчилгээ (Апостиль) + Сургуулиас олгосон төгсөлтийн гэрчилгээ (Аймаг, хотын боловсролын газар* баталгаажуулалт + Апостиль) + [Хавсралт 2] Сургуулийн мэдээллийг шалгах хуудас • Төвлөрсөн захиргаатай хотууд (Бээжин, Шанхай, Чүнчин, Тяньжин)-ын хувьд боловсролын газрын албан ёсны нэр нь "Боловсролын хороо" болно. ② Техникийн болон үйлдвэрийн сургууль Хүний нөөц, нийгмийн хамгааллын яамны албан ёсны вэбсайт (www.mohrss.gov.cn)-аас татаж авсан онлайн лавлагаа* + БНХАУ дахь Солонгосын консулын баталгаажуулалт • Зөвхөн онлайнаар үнэн зөвийг нь шалгах боломжтой тохиолдолд хүчинтэй Бусад ахлах сургуулийн боловсролтойд тооцогдох сургууль Сургуулиас олгосон төгсөлтийн гэрчилгээ (Апостиль) + Байгуулах зөвшөөрлийн гэрчилгээ* хуулбар (Зөвхөн албан ёсны боловсролын хөтөлбөрийг хүлээн зөвшөөрнө, нотариатын баталгаа шаардлагагүй) • Хуулийн этгээдийн гэрчилгээ (事业单位法人证书) эсвэл Хувийн сургуулийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл (民办学校办学许可证)

4. Дүнгийн тодорхойлолт

- Сүүлийн улирлын дүн багтсан дүнгийн тодорхойлолтыг ирүүлнэ.
- Солонгос/Англи хэлнээс өөр хэл дээрх бичиг баримт: Солонгос/Англи орчуулгын нотариатаар баталгаажуулсан эх хувийг ирүүлнэ.
- Хичээл тус бүрийн кредит, оноо эсвэл голч дүнгийн мэдээлэл заавал багтсан байх ёстой.
- Баримт бичгийг бүрдүүлэх хугацаанаас хойш 3 сарын дотор гаргасан/нотариатаар баталгаажуулсан бичиг баримт л хүчинтэй.

※ Эцсийн байдлаар төгсөлтийн гэрчилгээ аваагүй тохиолдолд өргөдөл гаргах боломжгүй.
※ Баримт бичгийг бүрдүүлэх хугацаанаас хойш 3 сарын дотор гаргасан/нотариатаар баталгаажуулсан бичиг баримт л хүчинтэй



5. Өргөдөл гаргагч болон эцэг эхийн иргэний харьяаллыг нотлох баримт [①+② Бүгдийг илгээнэ үү]
- ① Өргөдөл гаргагч болон түүний эцэг эхийн гадаад паспорт мөн эх орны иргэний үнэмлэхийн өнгөт хуулбар
 - ② Өргөдөл гаргагч болон түүний эцэг эхийн гэр бүлийн хамаарлыг нотлох баримт бичиг (эх хувь эсвэл нотариатаар гэрчлүүлсэн хуулбар)
- Хятадаас бусад улсын иргэн: Гэр бүлийн харилцааны гэрчилгээ эсвэл төрсний гэрчилгээ
- Хятад улсын иргэн: Ураг төрлийн гэрчилгээ, өрхийн бүртгэл
- Эцэг, эх нь гэрлэлт цуцлагдсан/нас барсан гэх мэт шалтгаанаар бичиг баримт бүрдүүлэх боломжгүй бол түүнийг нотлох төрийн байгууллагаас гаргасан баримт бичгийг бүрдүүлэх

6. Англи хэлнээс өөр хэл дээр байгаа бол Солонгос хэл рүү орчуулж нотариатаар баталгаажуулах шаардлагатай.

7. Бүх бичиг баримтыг хүлээн авах эцсийн хугацаанаас өмнөх 3 сарын дотор нотариатаар баталгаажуулсан тохиолдолд хүлээн авна.

6

Тэнцэгчийн бүртгэл визний мэдээлэл

ангилал	Солонгост оршин суугч	Гадаадад оршин суугч
Өргөдөл гаргах байршил	Чусон их сургуулийн Олон улсын хамтын ажиллагааны баг	Өөрийн оронд байгаа Солонгосын Элчин сайдын яам
Хүсэлтийн агуулга	D-2 виз рүү өөрчлөх (Жишээ: D-4 → D-2)	D-2 виз шинээр олгогдох
Хүсэлтийн агуулга	2025оны 7-р сарын дунд	(Визний бичиг баримтыг сургалтын төлбөрөө төлж, бүх бичиг баримтаа бүрдүүлсний дараа визний материал илгээнэ) 2025оны 7-р сарын дунд
Бүрдүүлэх бичиг баримт	Өргөдлийн маягт, гадаад паспортын хуулбар, 1 хувь цээж зураг, элсэлтийн жишиг хуудас, сургалтын төлбөр төлсөн баримт, хамгийн сүүлийн боловсролыг нотлох баримт бичиг, санхүүгийн чадамжийг нотлох баримт бичиг, Солонгос хэлний бэлтгэлд суралцсан гэрчилгээ болон дүнгийн тодорхойлолт, оршин суугаа газрыг нотлох баримт бичиг гэх мэт.	Өргөдлийн маягт, Гадаад паспорт, 1 хувь цээж зураг, элсэлтийн стандарт хуудас, санхүүгийн чадварыг нотлох баримт бичиг гэх мэт. (Өөрийн улсад суугаа Солонгосын консулын газрын цахим хуудаснаас шалгах шаардлагатай)
Хүсэлт Гаргах арга	Өргөдлийн бичиг баримтыг бэлтгэсний дараа Олон улсын хамтын ажиллагааны багт зочилох	Өргөдлийн бичиг баримтыг бэлтгэсний дараа эх орондоо байгаа Солонгосын ЭСЯ-нд зочлох, хүсэлт гаргах
Анхаарах зүйл	Оршин суух хугацаа дуусахаас өмнө өргөдөл гаргах шаардлагатай (семестр эхлэхээс өмнө) Виз солиход ойролцоогоор 5-8 долоо хоног шаардагдана.	Солонгост нэвтэрсний дараа гадаадын иргэний бүртгэлд бүртгүүлэх шаардлагатай

※ Виз олгох хугацаа хойшилсон, татгалзсан гэх мэт асуудлыг та өөрөө хариуцах ба сургалтын төлбөр төлсний дараа элсэх боломжгүй болсон тохиолдолд 2025 оны 8-р сарын 22(Баасан) хүртэл элсэлт цуцлах хүсэлтийн маягтыг бүрдүүлснээр сургалтын төлбөрийг бүрэн буцаан авах боломжтой.



Салбар	Тэнхимийн нэр		Шинэ элсэгч	Шилжин элсэгч		тэмдэглэл
			1-р курс	2курс	3курс	
Глобал хүмүүнлэгийн салбар	Солонгос хэл, уран зохиолын тэнхим●	Солонгос хэл,уран зохиолын мэргэжилтэй	○	○	○	
		Солонгос хэлний боловсролын мэргэжилтэн	○			
	Англи хэл ,уран зохиолын тэнхим		○	○	○	
	Түүх,соёлын тэнхим		○	○	○	
	Бүтээлч бичих тэнхим		○	○	○	
	Японы хэлний тэнхим		○	○	○	
	Азийн хэл,соёлын тэнхим●	Араб хэлний мэргэжилтэн	○	○	○	
		Хятад хэл,соёл судлалын мэргэжилтэн	○	○	○	
		Философийн мэргэжилтэн	○	○	○	
	Европын хэл, соёлын тэнхим●	Герман хэл,соёл судлалын мэргэжилтэн	○	○	○	
		Орос хэлний мэргэжилтэн	○	○	○	
		Испани хэлний мэргэжилтэн	○	○	○	
	Глобал бизнесийн харилцааны тэнхим		○	○	○	
	К-соёлын гүйцэтгэл, төлөвлөлтийн тэнхим		○	○	○	
Байгалийн шинжлэх ухаан, нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдлын салбар	Байгалийн шинжлэх ухааны тэнхим ●	Компьютерийн статистикийн тэнхим	○	○	○	
		Хагас дамжуулагч химийн тэнхим	○	○	○	
		Амьд биеийн зүйн шинжлэх ухааны тэнхим	○	○	○	
		Биоанагаахын шинжлэх ухааны тэнхим	○	○	○	
		Конверцийн математикийн шинжлэх ухааны тэнхим	○	○	○	
	Хүнс хоол тэжээлийн тэнхим		○	○	○	
	Цагдаа,захиргааны тэнхим		○	○	○	
	Зөвлөгөө өгөх сэтгэл судлалын тэнхим		○	○	○	
	Хөдөлмөрийн эмчилгээний тэнхим		○	○	○	
	Гал түймэр, гамшгийн удирдлагын тэнхим		○	○	○	
Хууль ба нийгмийн салбар	Хууль зүйн тэнхим		○	○	○	
	Олон нийтийн боловсон хүчин хуулийн тэнхим		○	○	○	
	Төрийн захиргаа халамж үйлчилгээний газар●	Төрийн удирдлагын мэргэжилтэн	○	○	○	
		Нийгмийн халамжийн мэргэжилтэн	○	○	○	
	Улс төр судлал,дипломат харилцааны тэнхим		○	○	○	
	Хэвлэл мэдээлэл харилцааны тэнхим		○	○	○	
Бизнесийн удирдлага салбар	Бизнесийн удирдлагын тэнхим		○	○	○	
	Эдийн засгийн тэнхим		○	○	○	
	Гадаад худалдааны тэнхим		○	○	○	

Салбар	Тэнхимийн нэр		Шинэ элсэгч	Шилжин элсэгч		тайлбар
			1курс	2курс	3курс	
Инженерийн салбар	Барилгын инженерийн тэнхим		○	○	○	
	Архитектурын инженерийн тэнхим★		○	○	○	
	Архитектурын тэнхим(5жил)		○	○	○	бүтээл
	Механик инженерийн тэнхим		○	○	○	
	Сансар судлалын тэнхим		○	○	○	
	Тэнгисийн болон тэнгисийн инженерийн тэнхим		○	○	○	
	Биохимийн инженерийн тэнхим		○	○	○	
	Шинэ материалын инженерийн тэнхим		○	○	○	
	Аж үйлдвэрийн инженерийн тэнхим★		○	○	○	
	Цахилгааны инженерийн тэнхим		○	○	○	
	Оптик технологийн инженерийн тэнхим★		○	○	○	
	Байгаль орчны инженерийн тэнхим		○	○	○	
	Цөмийн инженерийн тэнхим		○	○	○	
	Шинжлэх ухаан·инженерчлэлийн гагнуур		○	○	○	
	Эрчим хүчний инженерчлэлийн ахисан түвшний тэнхим		○	○	○	
Итнэгдсэн их сургууль	Электрон инженерчлэлийн тэнхим		○	○	○	
	AI программ хангамжийн тэнхим●	Компьютерийн инженер	○	○	○	
		Мэдээлэл харилцааны холбооны инженер	○	○	○	
		Мэдээллийн аюулгүй байдлын инженер	○	○	○	
		Хиймэл оюун ухааны инженер	○	○	○	
		Mobility SW мэргэжилтэн	○			
Урлаг биеийн тамирын салбар	Уран зургийн тэнхим●	Барууны зураач	○	○	○	Бүтээл,судалгааны төлөвлөгөө
		Солонгос зураач	○	○	○	
	Соёлын агуулгын тэнхим●	Орчин үеийн гоо зүйн хэвлэл мэдээллийн мэргэжилтэн	○	○	○	
		Тавилга,керамик дизайн мэргэжилтэн	○	○	○	
		График соёлын куратор мэргэжилтэн	○	○	○	
	Амьдралын хэв маягийн дизайны тэнхим●	Интерьер дизайны мэргэжилтэн	○	○	○	Бүтээл
		Нэхмэл,загварын мэргэжилтэн	○	○	○	
	График дизайны тэнхим		○	○	○	Бүтээл
	Дизайн инженерийн тэнхим		○	○	○	Бүтээл (тэнхимийн хүрээнд ярилцлага хийнэ)
	Комик ном · хүүхэлдэйн киноны тэнхим		○	○	○	Бүтээл 10хуудас(сүүлийн 2жилийн дотор хийсэн) эсвэл практизийн шалгалтаас 3 цагийн дараа ярилцлага хийнэ.
Биеийн тамирын тэнхим	Биеийн тамирын тэнхим		○	○	○	тэнхимийн хүрээнд ярилцлага хийнэ
	Спортын үйлдвэрийн газар		○	○	○	тэнхимийн хүрээнд ярилцлага хийнэ
	Таеквондогийн тэнхим		○	○	○	Пүн, Дан зэрэгтэй бол давуу тал болно
	Урлаг,бүжгийн тэнхим		○	○	○	
Глобал бакалаврын сургууль	Глобал бакалаврын сургууль●	Олон улсын худалдаа	○			
		Глобал бизнес	○			
		К-соёл, тайзны зохион байгуулалт	○			
		К-Спорт&Бүжиг	○			
		машин механизмын инженер	○			
		К-эрүүл мэндийн үйлчилгээ	○			

※ 「●」 : Бакалаврт элссэний дараа хоёр дахь жилээс нарийн мэргэжлийн хичээлүүд хувиарлагдаж эхэлнэ.

「★」 : Инженерийн боловсролын магадлан итгэмжлэлийн үнэлгээний нэгж

※ 5 жилийн сургалттай архитектурын ангид шилжин суралцагч нь өмнөх сургуульд судалсан мэргэжлийн хичээлүүдийн портфолио (хичээлийн төлөвлөгөө, даалгавар зэрэг хичээлийн агуулгыг баталгаажуулах материал)-г Архитектурын боловсролын олон улсын магадлан итгэмжлэлийн албанд гаргаж өгөх шаардлагатай бөгөөд, Солонгосын Архитектурын Боловсролын Магадлан Итгэмжлэлийн Хүрээлэн (КААВ)-ийн магадлан итгэмжлэлийн хөтөлбөрийн дагуу 1, 2 дугаар курст судлах ёстой анхан шатны болон магадлан итгэмжлэлд шаардлагатай хичээлүүдийг судлахын тулд шилжиж ирсний дараа үлдсэн семестр (6 семестр)-ээс хэтрэх боломжтой.





8 | Сургалтын төлбөр

ангилал	Тэнхим болон харьяа сургууль	Эхний улирал	Хоёр дахь улирлаас
Сургалтын төлбөр	Глобал бакалаврын сургууль, хүмүүнлэг /нийгмийн шинжлэх ухаан, Хэвлэл мэдээлэл,харилцааны тэнхим	3,151,800	3,025,000
	Байгаль, Биеийн тамирын тэнхим	3,667,800	3,541,000
	Инженерийн сургууль, IT нэгдсэн сургууль,Урлагийн сургууль	4,181,800	4,055,000

※ энэхүү төлбөр нь 2025-1улиралд суурилсан бөгөөд, өөрчлөгдөх боломжтой
※ Глобал бакалаврын сургууль нь 2-р курсээс нарийн мэргэжлээ сонгох учир салбараас хамааран сургалтын төлбөр өөр өөр байна.
※Сургалтын төлбөрийг улирал бүр төлөх бөгөөд шинэ, шилжин суралцаж байгаа болон одоо суралцаж байгаа оюутнуудын төлбөрийг хэсэгчлэн төлөх боломжгүй.

9 | тэтгэлэг

ангилал	төрөл	нөхцөл	хэлбэр	тэмдэглэл
Шинэ элсэгч	Элсэлтийн тэтгэлэг	ТОPIK 4 түвшнээс дээш	Төлбөр бүрэн хөнгөлнө	Зөвхөн элсэлтийн эхний семестрт хамаарна
		ТОPIK 3түвшин	Төлбөрийн 1/2	
		CSU-TOPIK тэнцсэгч	төлбөрийн 1/3	
Суралцаж буй оюутан	Дүнгийн тэтгэлэг	Өмнөх семестрийн голч дүн 4.2 ба түүнээс дээш	Сургалтын төлбөр бүрэн хөнгөлнө	Төгсөлтийн бус (Тогтоосон семестрээс хэтэрсэн оюутнууд) зэрэгтэй оюутнуудад олгох боломжгү
		Өмнөх улирлын голч дүн 3.8 ба түүнээс дээш, 4.2-оос бага	Сургалтын төлбөр 1/2 хөнгөлнө	
		Өмнөх улирлын голч дүн 3.5 ба түүнээс дээш, 3.8-аас бага	Сургалтын төлбөр 1/3хөнгөлнө	
		Өмнөх улирлын голч дүн 3.0 ба түүнээс дээш, 3.5-аас бага	Сургалтын төлбөр 1/4хөнгөлнө	
	ТОPIK тэтгэлэг	ТОPIK 4түвшин ба түүнээс дээш түвшинд хүрсэн оюутан	500,000вон	Улирал бүр зарлагдана, Төлбөрийн нөхцөл өөр байж болно

※ Энэхүү тэтгэлэг нь 2025 оны 1-р улиралд суурилсан бөгөөд өөрчлөгдөж болзошгүй.
※ Энэ тэтгэлэг нь элсэлтийн хяналтын тоонд багтаагүй гадаад оюутнуудын элсэлтийн журмын хүрээнд олгогдох ба элсэлтийн төрлөөс хамааран тэтгэлгийн журам өөр өөр байна

10 | Бусад мэдээлэл, анхаарах зүйлс



13

1. Хичээл эхлэх өдөр: 2025. 9. 1.(даваа)

2. Чиг баримжаа олгох сургалт: 2025. 9. 1.(даваа) 09:30цагт төлөвлөсөн

※ Хичээл сонголт болон визтэй холбоотой мэдээллийг зарлах тул шинээр элсэх бүх оюутнууд заавал хамрагдах шаардлагатай.

3. Хичээл сонголт

- 1) Хугацаа: Улирал бүр хичээл эхлэхээс 2 долоо хоногийн өмнө (тодорхой хуваарийг улирал бүр зарладаг)
- 2) Сургуулийн дотоод системээр дамжуулан хүсэлт гаргах
- 3) Өргөдөл гаргах кредит: Семестр бүр дор хаяж 17-19 кредит цуглуулах

4. Төгсөлтийн кредит

ангилал	Судлах кредит
Глобал бакалаврын сургууль	110 кредит
Ерөнхий тэнхим	130 кредит
Хууль зүй,нийгмийн коллеж, IT нэгдсэн тэнхим	140кредит
Архитектурын тэнхим,архитектурын мэргэжил (5жил)	160кредит

※※ Бусад тэнхим, мэргэжлүүдтэй холбоотой мэдээллийг сургуулийн вэб сайтаас авна уу.

5. Төгсөх нөхцөл

■ Глобал бакалаврын сургууль: Төгсөхийн тулд шаардлагатай кредитийг гүйцээх

■ Ерөнхий тэнхим

- 1) ТОPIK-ийн 4 ба түүнээс дээш түвшний оноо (Солонгос хэл, уран зохиолын 5 ба түүнээс дээш түвшин) авах (Олон улсын хамтын ажиллагааны багт тайлангийн хуудсыг ирүүлэх)
- 2) Оюутнууд элссэний дараах эхний жилдээ олон улсын оюутнуудад зориулсан солонгос хэлний тусдаа хичээлийг дор хаяж 6 кредитээр дүүргэсэн байх ёстой.
- 3) Төгсөлтийн кредит болон бусад төгсөлтийн шаардлага нь тэнхим бүрт өөр байдаг тул элссэнийхээ дараа тэнхимийн сургалтын албанаас лавлахыг зөвлөж байна.

6.Үндэсний эрүүл мэндийн даатгал

- 1) Бүртгүүлэх огноо: Гадаадын иргэнээр бүртгүүлэхэд автоматаар бүртгэгдэнэ.
 - Гадаадын иргэний бүртгэл дуусах хүртэл элсэлт хийх боломжгүй. Иймд бүртгэлээ дуусгахаасаа өмнө эмнэлгээр үйлчлүүлнэ үү. Үүнтэй ижил тохиолдолд аюулгүй байдлын үүднээс тусдаа даатгал хийхийг зөвлөж байна.
- 2) Сард төлөх хураамж : 76,390вон
 - Дээрх дүн нь 2025 оны дүнгээр тооцсон бөгөөд цаашид нэмэгдэх магадлалтай.
 - Хэрэв 6-аас дээш сарын хугацаанд Солонгост оршин суувал гадаад иргэний бүртгэлийн өдрөөс эхлэн автоматаар даатгалд хамрагдана.
- 3) Төлбөрийн арга: Гэрийн хаягаар төлбөрийн нэхэмжлэх ирж, төлбөрийн дүн, дансны дугаарыг шалгасны дараа төлнө.



11 | Дотуур байр

1. Шинэ оюутнууд дотуур байранд эсвэл гадуур амьдрах боломжтой (**Өргөдөл гаргасны дараа өөрчлөлт оруулах боломжгүй**)
2. Дотуур байрны оршин суугчид эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж, халдварт болон сэтгэцийн өвчтэй хүмүүсийг дотуур байрнаас гаргах арга хэмжээ авна.
3. Байранд орохын өмнө <Сүрьеэгийн оношилгоо> үр дүнгийн хуудсыг ирүүлэх
- Виз мэдүүлэхдээ эрүүл мэндийн үзлэгийн дүн, сүрьеэгийн шинжилгээний хариуны хуулбар (англи хэл) ирүүлэх
4. Дотуур байрны танилцуулга

ангилал	Төлбөр	Хоолны төлбөр		тайлбар
		Өдөрт 1хоол(нийт75)	Өдөрт 2хоол(нийт150)	
Бэкхагхагса	2хүний	1,194,000вон	300,000вон (1хоолны 4,000вон)	- Нийтийн бие засах газар/шүршүүрийн өрөө - air conditoner/халаалтын систем
	1хүний	796,000вон		
Глобал хаус	2хүний	1,402,000вон	555,000вон (1хоолны 3,700вон)	- Өрөөндөө бие засах газар/шүршүүрийн өрөө - air conditoner/халаалтын систем
	1хүний	935,000вон		
Грийн вийлэж(эр)	2хүний	796,000вон		- Өрөөндөө бие засах газар/шүршүүрийн өрөө
Грийн вийлэж(эм)	2хүний	796,000вон		- Нийтийн бие засах өрөө/шүршүүрийн өрөө

- * Дээрх дотуур байрны төлбөр нь 2025оны 1-р семестрийн байдлаар ба сургуулийн нөхцөл байдлаас шалтгаалан өөрчлөгдөж болно.
- 2 хүний өрөөг 1 хүн авах хүсэлт гаргах боломжтой (1хүний өрөөний төлбөр төлнө)
 - Green Village нь дотуур байранд хоол хийхийг зөвшөөрдөг бол Baekhakhaksa болон Global House байранд хоол хийхийг зөвшөөрдөггүй харин дотуур байрны хоолны газарт заавал хоолох сонголт хийх шаардлагатай (Өдөрт 1 удаа эсвэл 2 удаа хооллох сонголтоос сонгоно)
 - **Дотуур байранд орох хүсэлтийг бүртгүүлсэн дарааллаар авдаг бөгөөд дээд хязгаараас хэтэрсэн тохиолдолд байрнд орох боломжгүй.**
- * Байранд орох үйл явц
- Хүсэлт гаргахдаа дотуур байраа сонгох → Байрнд орохын өмнө дотуур байрны 1 давхарт байрлах захиргааны албанд зочилно. → Өрөөний түлхүүр, гудасны бүрээсийг хүлээн авах
 - Матрасны хэмжээ: Та дотуур байрнаас өгсөн матрасын бүрээс эсвэл өөрийн матрасын бүрээсийг ашиглаж болно.
 - 1) Бэкхагхагса байр: 195cm × 99cm × 22cm
 - 2) Глобал хаус байр: 198cm × 98cm × 21cm
- *Бэлтгэх зүйлс
- Иргэний үнэмлэх, орны дэвсгэр (ширмэл/дан дэвсгэр хэрэглэхгүй), хөнжил, дэр, ариун цэврийн хэрэгсэл, хувцасны өлгүүр, шаахай гэх мэт.
 - Хориотой эд зүйлсийг дотуур байрны цахим хуудаснаас үзнэ үү.
(<https://u.chosun.ac.kr/csu/HT6g9158OZ/ul.do>)
- *холбоо барих дугаар:
- 062-608-5961 (Бэкхагхагса- эр) / 062-608-5952(Бэкхагхагса- эм)
 - 062-608-5155~6 (Глобал хаус) / 062-608-5000(Грийн вийлеж)

12 | Анхаарах зүйлс ★★★

Өргөдөл гаргахад анхаарах зүйлс

1. Өргөдөл гаргах эцсийн хугацаа хүртэл шаардлагатай бүх мэдээллийг оруулж, баримт бичгийг шуудангаар илгээх эсвэл өөрийн биеэр авч ирж бүртгэлээ бүрэн дуусгах.
※Баримт бичгийг онлайнаар илгээхдээ Солонгос/Англи хэл дээрх эх хувь, эсвэл нотариатаар баталгаажуулсан орчуулгыг өнгөт сканнер хийж PDF файл болгон, онлайн өргөдөл игээсний дараа бүх бичиг баримтыг шуудангаар эсвэл биечлэн ирүүлэх ёстой.
2. Та өргөдлийн шаардлага, өргөдөл гаргаж буй тэнхим, дотуур байранд бүртгүүлэх эсэхээ сайтар шалгаж, сонгох ёстой. Өргөдөл гаргах эцсийн хугацаа дууссаны дараа өөрчлөлт оруулах боломжгүй (Бүртгэлийн хугацаанд өргөдөл гаргаж буй тэнхимээ өөрчилж болно).
3. Элссэний дараа мэргэжлийг өөрчлөх боломжгүй тул элсэх гэж буй тэнхимээ сайтар бодож сонгох.
4. Нэг өргөдлийн хугацаанд хэд хэдэн өргөдөл гаргасан тохиолдолд сүүлийн өргөдлөөс бусад өргөдлийг хүчингүйд тооцно.
5. Өргөдөл гаргагч нь өөрийн цахим шуудан болон утасны дугаараа оруулах ёстой бөгөөд өөр хэн нэгний мэдээлэл оруулсан, буруу мэдээлэл оруулснаас үүдэн гарах алдаа хохиролыг өргөдөл гаргагч өөрөө хариуцна.
6. Хуулбарыг ирүүлсэн тохиолдолд заасан хугацаандаа баримт бичгийн эх хувийг бүрдүүлнэ. Эх хувилбараас өөр байх тохиолдолд хохирол учирч болзошгүйг санан анхааралтай бүрдүүлэх.
7. Шуудангийн бичиг баримт ирснийг баталгаажуулсан лавлагааг хүлээн авахгүй, ирүүлсэн баримт бичгийг буцаан олгохгүй.



Өргөдөл гаргагч анхаарвал зохих зүйлс

1. Төгсөхөөр хүлээгдэж буй тохиолдолд манай сургуульд элсэн орохоос өмнө зохих эрдмийн зэрэг авч чадаагүй бол элсүүлэх боломжгүй.
2. Төгсөх (курсыг дүүргэх) төлөвтэй гэсэн гэрчилгээ өгсөн тохиолдолд, элсэлтийн дараа сургуульд элсэхээс өмнө төгсөлтийн (курсыг дүүргэсэн) гэрчилгээг заавал өгөх ёстой. Хэрэв уг гэрчилгээг өгөх боломжгүй бол элсэлтийг хүчингүй болгоно
3. Өргөдлийн бүх бичиг баримтыг (Хэлний мэдлэгийн дүнгийн хуулбарыг оруулаад) хүлээн авах эцсийн хугацаанд ирүүлээгүй тохиолдолд татгалзана.
4. Хэрэв хуурамч бичиг баримт бүрдүүлсэн, худал мэдээлэл бэлтгэсэн, боловсролын шаардлага хангаагүй нь тогтоогдвол (тухайн улсын зөвшөөрөлгүй их сургууль) таны эрхийг хасч, элсэлтийг цуцална.
5. Шалгалтын явцад шаардлагатай тохиолдолд нэмэлт бичиг баримт шаардаж болох ба шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлээгүй тохиолдолд элсэх эрхийг хасна.
6. Солонгос эсвэл Англиас бусад хэл дээр бичигдсэн баримт бичгийн хувьд нотариатаар баталгаажуулсан орчуулгыг ирүүлнэ үү.
7. Апостиль/Консулын баталгаажуулалт/Эрдмийн зэргийг баталгаажуулсан гэрчилгээнүүдтэй холбоотой мэдээлэл авахыг хүсвэл холбогдох байгууллагатай харилцаж, өргөдлийн бичиг баримт бүрдүүлнэ.
8. Бүрдүүлсэн бүх бичиг баримтыг буцааж өгөхгүй. Баримт бичгийг бэлтгэхдээ дараа нь виз мэдүүлэхэд хэрэглэгдэх нэмэлт бичиг баримтыг давхар бэлтгэхийг зөвлөж байна.
9. Элссэнээс хойш нэг жилийн хугацаанд мэргэжлээ солих, эхний семестрийн чөлөө авах боломжгүй.
10. Глобал судлалын тэнхимээс бусад гадаад оюутан шинэ элсэгчид төгсөхөөс өмнө TOPIK 4-р түвшин буюу түүнээс дээш үнэлгээ авах (Олон улсын хамтын ажиллагааны албанд онооны хуудас өгч баталгаажуулах) шаардлагатай.※ Элссэний дараах эхний 1 жилийн хугацаанд гадаад оюутнуудад зориулсан солонгос хэлний ерөнхий хичээлээс дор хаяж 6 кредит судлах ёстой.※ Төгсөх кредит болон бусад төгсөх шаардлага нь тэнхим бүрээс хамааран өөр тул, элссэний дараа заавал харьяа тэнхимийн оффист хандан мэдээлэл авахыг зөвлөж байна.
11. Сургуульд тэнцсэний дараа зөвхөн бүртгэлийн хугацаанд сургалтын төлбөрөө төлсөн элсэгчдэд “Элсэлтийн жишиг гэрчилгээ”-г шуудангаар илгээнэ. Харин сургалтын төлбөрөө төлөөгүй тохиолдолд хүлээн авалтыг цуцална.
12. Сургалтын төлбөрөө төлсний дараа элсэлтээ цуцалж сургалтын төлбөрөө буцаан авах хүсэлт гаргавал буцаан олголтын шимтгэлийг өөрөө хариуцна.
13. Манай сургуулиас стандарт элсэлтийн бичиг гаргасан байсан ч тухайн улс дахь Солонгосын элчин сайдын яам (консулын газар), дотоодын цагаачлалын албанаас оюутны виз олгоогүй, сунгагдаагүй (өөрчлөгдөөгүй) тохиолдолд элсэх эрхийг цуцална.
14. Хоёр ба түүнээс дээш их дээд сургуульд элссэн өргөдөл гаргагчид зөвхөн нэг их дээд сургуульд бүртгүүлэх ёстой бөгөөд үүнийг зөрчсөн тохиолдолд элсэлт цуцлагдах болно
15. Сонгон шалгаруулалтын хуваарь болон нөхцөл өөрчлөгдөж болох ба өөрчлөлт орсон тохиолдолд дараа мэдэгдэх болно.
16. Элсүүлэх зааварт заагаагүй асуудлыг Чусон их сургуулийн эрдэм шинжилгээний дүрэм, удирдамж, бусад асуудлыг Их сургуулийн Олон улсын харилцааны хороо, Олон улсын хамтын ажиллагааны багийн шийдвэрээр шийдвэрлэнэ
17. Энэхүү удирдамж Солонгос, Англи, Хятад, Вьетнам, Монгол хэлээр бичигдсэн бөгөөд тайлбарын зөрүүтэй тохиолдолд Солонгос хэл дээр бичсэн агуулгыг стандарт болгон ашиглана.



[붙임1] 번역자확인서 (Translator Confirmation)



확 인 서 (번역자)

번역자 인적사항			
국적	성명	생년월일	성별
주소			연락처(☎)
번역물 원본의 명의인 인적사항			
국적	성명	생년월일	성별
번역 대상물			

첨부한 번역 내용은 원본의 문구에 맞게 사실대로 번역하였으며, 번역 내용이 사실과 다른 경우에는 이에 따른 모든 법적 책임을 감수하겠습니다.

20

번역자 :

법무부장관 귀하

※1 제출서류중 영어나 한국어가 아닌 서류는 공증된 번역본을 위 확인서와 같이 제출하십시오.
※ Documents in non-Korean or non-English languages must be accompanied by certified English or Korean translations with the above confirmation.

붙임(양식)

[붙임2] 학교정보 확인서 (学校信息确认书)

학교 정보 확인서 学校信息确认书

유학생 인적사항 留学生 个人信息	성명 姓名		생년월일 出生日期	
	국적 国籍		여권번호 护照号码	
	진학 예정 대학 拟入学大学名称		전공명 专业名称	
	전화번호 联系电话		e-mail 电子邮箱	
학교정보 学校信息	졸업학교명 (졸업일) 毕业学校名称 (毕业日期)	(졸업일 毕业日期: 2022. . .)		
	학교유형 学校类型	보통중등전문학교 普通中专 () 성인중등전문학교 成人中专 ()	직업고등학교 职业高中 () 기타 其他 ()	
	교육과정 教育种类	고등학교 학력과정 高中阶段学历教育() 고등학교 비학력과정 高中阶段非学历教育() ※ 비학력 과정의 경우 유학비자 발급 불가 非学历教育学生不能获得韩国留学签证		
	소재지 学校地址			
	전화번호 学校电话			
	홈페이지 学校官网			
교직원 연락정보 教职工 联系信息	소속 및 직위 所属部门及职位			
	성명 姓名	(인 또는 서명) (盖章或签名)	전화번호 联系电话	

본인은 상기 학교 정보 등 기재 내용이 사실과 다름없음을 서약하며, 허위 사실 기재 시 대한민국 법령에 따라 처벌받을 수 있음을 확인합니다.
本人保证，以上所填写的学校信息等内容均属实。本人理解，以上信息如有虚假，可能会受到韩国相关法律法规的处罚。特此确认。

20

유학생 본인 留学生本人 (서명 签名)

* 2부 작성 후 교육기관 및 재외공관에 각각 제출
本确认书需要一式两份。一份交拟入学大学，一份交韩国驻外使领馆。

붙임(양식)

[붙임3] 학력인증조회 요구서 (Request for Academic Credentials Verification)

☞ Recent University Only

Applicant's Information(Written by applicant)

Name	
Date of Birth (yyyy/mm/dd)	
Name of School	
Information on Records & Transcripts Office	CU will check the applicant's educational background by below the e-mail address during the screening period. So, please fill in the exact e-mail address.
	E-mail: _____ Office Number: ()
Dates of Attendance	From YYYY/MM/DD To YYYY/MM/DD
Date of Graduation	

The following section is for the staff of Records & Transcripts Office(The Registrar) at the university where the applicant most recently has earned or is to earn the diploma.

VERIFICATION REPORT(Written by the Registrar)

Applicant's Degree	Field of Study	Date of Graduation

I hereby verified and confirm that the above information (Verification Report) is true and correct.

Name of person completing this report: _____

Title: _____ Signature: _____

Contact Number : () _____

E-mail address: _____ @ _____

Date : _____

※ Applicants who earned a degree(Bachelor's degree or Master's degree) in Korea don't have to fill out this form. Applicants Only who got a degree abroad should fill in above form.

※1 제출서류중 영어나 한국어가 아닌 서류는 공증된 번역본을 위 확인서와 같이 제출하십시오.

※2 Documents in non-Korean or non-English languages must be accompanied by certified English or Korean translations with the above confirmation.



조선대학교
CHOSUN UNIVERSITY

ЧУСОН ИХ СУРГУУЛЬ

Бакалавр хариуцсан хэлтэс

Гуанжу гуанёогши Дунгү Чусон их сургууль 5гил 9, Чусон их сургууль (гадаад харилцааны алба 1-р давхар)
ОУ хамтын ажиллагааны баг “Бакалавр хариуцсан хэлтэсийн дарга”

Шуудангийн дугаар:61452

Утасны дугаар:062-230-6495

International Affairs Team ‘Foreign Undergraduate Officer’

Address: Chosun University, 9, Chosundae 5-gil, Dong-gu, Gwangju, Republic of Korea

Postal code: 61452

Phone number: +82-62-230-6495

Email: admission@chosun.ac.kr / jsw0368@chosun.ac.kr

Website: <https://www.chosun.ac.kr/eng>